

“Хот девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын протокол

2013.04.11

Улаанбаатар хот

“Хот девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2013 оны 04 сарын 11-ны өдрийн 12 цагаас “БиДиСек” ХК-ийн хурлын өрөөнд эхлэв.

Хуралд: Тооллогын комиссын даргаар “БиДиСек” ХК-ийн Т.Отгонцэрэн, тооллогын комиссын гишүүнээр А.Болормаа, “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлж О.Пүрэвдорж, “Хот девелопмент” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Пүрэвбаатар, “Хот девелопмент” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг Ё.Лхагважаргал нар оролцож нийт ирц 82.05% хурал нээснийг мэдэгдэв.

Хуралд даргалагчаар Б.Пүрэвбаатар сонгогдов.

Өнөөдрийн хуралд хэлэлцэх асуудал, холбогдох материалыг урьдчилан хүргүүлсэн учир өөр санал байгаа эсэхийг хурал даргалагч асуув. Оролцогчид өөр саналгүй гэв.

Хэлэлцсэн нь:

Гүйцэтгэх захирал Б.Пүрэвбаатар танилцуулга хийв.

Б.Пүрэвбаатар – Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе!

Эхлээд та бүхэнд манай “Хот девелопмент” ХК буюу хуучнаар “Шад трейд” ХК нь шинэ нэр болон бүтэцтэйгээр 2013 оныг угтаж байгааг хувьцаа эзэмшигч та бүхэнд дуулгахад таатай байна. Компанийн хувьцаа эзэмшигчид болон тэдний төлөөлөл болсон Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага 2012 онд хуучин байсан хувьцаат компанийн статусыг хэвээр хадгалж олон нийтийн өмчийн оролцоотой нээлттэй компани байдлаар цаашид үйл ажиллагааг сэргээхээр зорилт тавин ажиллаа. 2013 оны 8 сарын 30 өдөр хуралдсан Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн нэрийг “Хот девелопмент” ХК болгон өөрчилж ТУЗ-ийн бүтцийг шинээр баталлаа.

Өнөөдрийн “Хот девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар бид ТУЗ-ийн гишүүд томилох, 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг батлах, 2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах, ТУЗ-ийн 2013 оны төсөв батлах тухай асуудлуудыг хэлэлцэнэ.

Б.Пүрэвбаатар – Хурлын танилцуулга дээр ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга байгаа та бүхэн үзэж танилцана уу.

Асууж лавлах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё.

2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг харна уу.

Б.Батбаатар – 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай танилцсан. Ямар нэг асуулт байхгүй.

Б.Пүрэвбаатар – Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байгаа.

2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах тухай асууж тодруулах зүйл байна уу?

О.Пүрэвдорж – 2013 оны төсөвтэй танилцлаа. Харин компанийн 2013оны цаашдын зорилт юу байна вэ?

Б.Пүрэвбаатар – 2013 онд бид бүхэн компанийн шинэ салбарт гаргаж ирэх, нэмэлт хөрөнгө оруулалт босгох, өөрсдийн төслүүдийг эхлүүлэх санаачлага гарган ажиллахаар зорьж байна.

ТУЗ-ийн 2013 оны төсөвт анхаарлаа хандуулна уу. Асууж тодруулах зүйл байна уу?

О.Пүрэвдорж – Байхгүй.

Б.Пүрэвбаатар – За ингээд манай өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлууд дууслаа. Та бүхэнд саналын хуудас тарааж өгсөн байгаа, саналаа өгнө үү.

Одоо хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар цуглуулж хурлын дараа тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах ба гишүүдийг томилох болно.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Ё.Лхагважаргал санал хураалтын дүнг танилцуулсан ба компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Жеймс Пассин 12,13%, Б.Батбаатар 12,13%, Б.Пүрэвбаатар 12,13%, Жеймс Эй Флорэс 10,09%, Д.Даянбилгүүн 10,09%, Б.Лхагвадорж 10,09%-ийн санал авч хараат гишүүдэд сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Б.Батхуяг 10,09%, Д.Нарангоо 10,09%, Т.Тамир 10,09%-ийн саналтайгаар сонгогдлоо.

Хурлаар хэлэлцсэн бусад Засуудлыг хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн гэж мэдэгдлээ.

Б.Пүрэвбаатар – За ингээд өөр хэлэлцэх асуулт байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж байна.

Хурлын протокол хөтөлсөн

Хурлын протокол хянасан

Ё. Лхагважаргал


Ё.ЛХАГВАЖАРГАЛ

Б.ПҮРЭВБААТАР